



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/628

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хүүхэд, өсвөр үеийнхнийг хичээлийн бус цагаар хамруулсан секц, дугуйлан, сургалт явуулж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, орчин нөхцөлтэй танилцан, хяналт шалгалт хийж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин, стандартыг хангуулах, хөгжлийг нь дэмжсэн үр дүнтэй, тогтвортой үйлчилгээг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Хууль тогтоомж, журам, стандартын хүрээнд хяналт шалгалтын ажлыг явуулж, хамрагдсан объект, секц, сургалт, дугуйлан нэг бүрээр дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж салбар зөвлөлийн IV хуралдаанд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Ч.Дашбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
...дүгээр сарын ...-ний өдрийн ...р
захирамжийн хавсралт

ХҮҮХДИЙГ ХАМРУУЛСАН СУРГАЛТ, СЕКЦ, ДУГУИЛАНГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРЧИН НӨХЦӨЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)

Гишүүд:

М.Үүрийнбаяр (Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

О.Бадраа (Аймгийн Боловсролын газрын дарга)

Д.Мөнхжаргал (Аймгийн Цагдаагийн газрын дарга)

С.Ганболд (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)

Т.Раднаабүд (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл, урлагийн газрын дарга)

Б.Очирбат (Аймгийн Биеийн тамир, спортын газар)

Б.Базардамбуу (Аймгийн Статистикийн хэлтсийн дарга)

Б.Мөнгөнзул (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Ч.Дашбаяр (Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга,
Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч)

_____оОо_____